**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 31 өдөр    Дугаар А/1743.    Улаанбаатар хот

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 101 дүгээр тогтоол, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газраас шилжин ирсэн 31,875,000.0 (гучин нэгэн сая найман зуун далан таван мянга) төгрөгийн үнэ бүхий ашиглалтын хугацаа дууссан тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ    В.ОЮУМАА

1150502100

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны
өдрийн A/243 дугаар тушаалын хавсралт

Дахин үнэлсэн хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Улсын бүртгэлийн газар

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтад авсан он | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Цаашид ашиглах жил | Дахин үнэлсэн нэг бүрийн үнэ | Дахин үнэлсэн нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Суудлын автомашин Соната-7 | 2011 | 1 | 31,785,000.00 | 31,785,000.00 | 31,785,000.00 | - | 6 | 9,000,000.00 | 9,000,000.00 |
| Нийт дахин үнэлэх хөрөнгийн дүн | | | | | 31,785,000.0 | | | | | 9,000,000.00 |